



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Архивын Ерөнхий Газрын АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН СУРГАЛТАД ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Захиалагч:

Архивын Ерөнхий Газар

2022.12.23

Гүйцэтгэгч:

Цогц Хөгжлийн Үндэсний Төв

Агуулга

УДИРТГАЛ	3
Судалгааны зорилго, зорилт.....	3
Судалгааны арга зүй	3
Судалгааны түүвэр	4
Бүлэг I. Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл.....	5
БҮЛЭГ II. Сургалтын хөтөлбөр болон багшийн үнэлгээ.....	11
БҮЛЭГ III. Сургалтын орчин нөхцөлийн үнэлгээ	18
Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ	21
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	22

Графикийн жагсаалт

График 1. Судалгаанд оролцогчдын насны бүтэц	5
График 2. Судалгаанд оролцогчдын хүйс.....	5
График 3. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин	5
График 4. Судалгаанд оролцогчдын байршил	6
График 5. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлт.....	6
График 6. Судалгаанд оролцогчдын ажлын байрны чиг үүрэг.....	6
График 7. Сургалтад оролцсон хэлбэр.....	7
График 8. Сургалтад оролцсон төрөл	7
График 9. Сургалтад хамрагдсан шугам.....	7
График 10. Сургалтад хамрагдсан шалтгаан.....	8
График 11. Бусад адил төрлийн сургалт явуулдаг байгууллагын талаар мэддэг эсэх	9
График 12. Ямар шалтгаанаар АЕГ-аас зохион байгуулдаг сургалтыг сонгосон.....	9
График 13. Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын талаарх мэдээлэл хүлээн авдаг суваг.....	9
График 14. Сургалтын талаар бусад хүмүүст санал болгох эсэх	11
График 15. Сураглтын үнэ тохиромжтой байдал.....	11
График 16. Сургалтаар олж авсан мэдлэг, чадвар ажлын байранд хэр зэрэг хэрэг болдог байдал	11
График 17. Сургалтаар олж авсан мэдлэг, чадвар хэрэглэгддэг байдал ажлын байраар	12
График 18. Сургалтын чанарыг сайжруулах тал дээр гаргасан санал (нээлттэй асуулт)	14
График 19. Сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвартаа сэтгэл ханамжтай байдал 0-10 оноогоор..	16
График 20. Сургалтын орчин, нөхцөлтэй холбоотой санал (нээлттэй асуулт)	19
График 21. Танхимын сургалтын орчин, нөхцөлийн сэтгэл ханамжийн үнэлгээ (0-10 оноогоор үнэлэв).....	20
График 22. Онлайн сургалтын нөхцөл байдлын үнэлгээ (0-10 оноогоор)	20
График 23. Онлайн сургалтын үед тохиолддог хүндрэлүүд.....	21

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Ажил элхлэлтийн нөхцөл байдал болон сургалтад суусан зорилго.....	8
Хүснэгт 2. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ	12
Хүснэгт 3. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, сургалтын хэлбэрээр	13
Хүснэгт 4. Хөтөлбөрийн үнэлгээ , насны бүлгээр	13
Хүснэгт 5. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, оршин сууж буй газраар	14
Хүснэгт 6. Сургалт орсон багшийн үнэлгээ	15
Хүснэгт 7. Багшийн үнэлгээ, насны бүлгээр	15
Хүснэгт 8. Багшийн үнэлгээ, оршин суугаа газраар.....	16
Хүснэгт 9. Сэтгэл ханамжийн үнэлгээ (0-10 оноогоор), сургалтын төрөл, хэрбэрээр	17
Хүснэгт 10. Сургалтын орчин нөхцлийн үнэлгээ.	18
Хүснэгт 11 Орчин нөхцөлийн үнэлгээ, насны бүлгээр	18
Хүснэгт 12. Орчин нөхцөл, оршин суугаа газраар	19
Хүснэгт 13. Танхимын болон онлайн сургалтын орчин нөхцөлийн үнэлгээ	21
Хүснэгт 14. “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт”-д хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ	21

УДИРТГАЛ

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 189 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Архивын ерөнхий газрын “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт”-ын 2022 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээний судалгааг “Цогц Хөгжлийн Үндэсний Төв” ТББ хийж гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго нь АЕГ-аас зохион байгуулдаг “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт”-д 2022 онд хамрагдагсдын сэтгэл ханамжийг тодорхойлох юм. Уг зорилгын хүрээнд дараах 3 зорилтыг дэвшүүллээ:


1. Сургалтын хөтөлбөрт хэр сэтгэл ханамжтай байгааг тодорхойлох
2. Сургалтын багш нар хэр сэтгэл ханамжтай байгааг тодорхойлох
3. Сургалтын орчин нөхцөлд хэр сэтгэл ханамжтай байгааг тодорхойлох

Судалгааны арга зүй

Судалгааны ажлыг дараах үе шатны дагуу гүйцэтгэлээ.

Үүнд: 1. Судалгааны бэлтгэл үе шат, 2. Мэдээлэл цуглуулах үе шат, 3. Тайлагнах үе шат болно.

Бүдүүвч. Судалгааны ажлын арга зүйн зураглал



Судалгааны бэлтгэл үе шат

- Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах
- Тайлангийн бүтэц гаргах
- Хэрэглэгдэхүүнийг эцэслэн батлах



Мэдээлэл цуглуулалтын үе шат

- Асуулга судалгаа
- Дата мэдээллийг хянах, шалгах
- SPSS программд өгөгдлийг оруулах



Тайлагнах үе шат

- Судалгааны мэдээлэлд чанарын хяналт хийх
- Мэдээлэлд шинжилгээ хийх /SPSS программ/
- Судалгааны тайлан бэлтгэх
- Эцсийн тайлан

Судалгааны түүвэр


Судалгааг CAPI /Computer Assisted Telephone Interview/ арга зүйн хүрээнд явууллаа.

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2022 онд “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт”-д хамрагдсан нийт 859 иргэдээс санамсаргүй байдлаар түүвэрлэн нийт 256 хүнийг судалгаанд хамрууллаа.

2022 онд “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт”-д хамрагдсан нийт 859 иргэдээс 517 хүн анхан шатны сургалтад хамрагдсан бол 342 хүн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.

Бүлэг I. Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл

График 1. Судалгаанд оролцогчдын насны бүтэц



АЕГ-ын Архив албан хэрэг хөтлөлтийн сургалтын сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчдыг насны бүтцээр авч үзвэл 25-44 насныхан хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин 45-54 насны оролцогчид хамгийн бага буюу 12.5 хувь байна. 24 хүртэлх насны

залуучууд судалгаанд оролцогчдын 20 хувийг бүрдүүлж байна.

График 2. Судалгаанд оролцогчдын хүйс

Судалгаанд оролцогчид хүйсийн хувьд эрс ялгаатай байлаа. Тухайлбал судалгаанд оролцогчдын ердөө 8.2 хувь нь эрэгтэй хүн байна. Үүний шалтгаан нь манай оронд тус чиглэлийн ажлын байранд гол төлөв эмэгтэйчүүд ажилладаг учир холбон тайлбарлаж болох юм.





График 3. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин



Боловсролын хувьд судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь буюу 76.6 хувь нь дээд, бакалаврын зэрэгтэй байгаа бол 12.5 хувь нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй байна. Өөрөөр нийт оролцогчдын 89.1 хувь нь дээд боловсрол

эзэмшсэн байна.

График 4. Судалгаанд оролцогчдын байршил

Судалгаанд оролцогчд байршлын хувьд 59 хувь нь Улаанбаатар хотоос, 41 хувь нь орон нутгаас ирж сургалтад хамрагдсан байна. Судалгааны хүрээнд хот хөдөөгийн харьцааг жигд тархааж судалгааны мэдээлэл цуглуулалт хийж гүйцэтгэсэн гэж үзэж байна.





График 5. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлт



Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг графикт харууллаа. Судалгаанд хамрагдсан иргэдийн хамгийн өндөр хувийг төрийн албан хаагчид бүрдүүлж байна. Харин


хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэгчид 8.2 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 5.5 хувийг, Оюутан, сурагч 0,4 тус тус бүрдүүлж байгаа бол 2.7 хувь нь хөдөлмөр эрхлэхгүй байна.

График 6. Судалгаанд оролцогчдын ажлын байрны чиг үүрэг



Ажлын байранд гүйцэтгэж байгаа чиг үүргийн хувьд нийт судалгаанд оролцогчдын 62.9 хувь нь архив, бичиг хэргийн чиглэлээр ажилладаг байна.


График 7. Сургалтад оролцсон хэлбэр



2022 онд сургалтад хамрагдсан иргэдийн тодорхой хэсэг нь цахимаар “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт”-д хамрагдсан байлаа. Харин манай судалгаанд хамрагдсан иргэдийн 72.7 хувь нь танхимын сургалтад хамрагдсан иргэд, үлдсэн


хэсэг нь онлайн хэлбэрээр хамрагджээ.

График 8. Сургалтад оролцсон төрөл




Архивын ерөнхий газрын газрын “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт” нь Анхан шатны сургалт, мэргэшүүлэх сургалт, захиалгат сургалт гэсэн үндсэн чиглэлээр явагддаг билээ. Энэ удаагийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчдын 73 хувь нь анхан шатны сургалтад, 14.8 хувь нь мэргэшүүлэх сургалтад, 12.1 хувь нь анхан шат, мэргэшүүлэх аль алинд нь хамрагдсан байна.

График 9. Сургалтад хамрагдсан шугам



“Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт”-д хамрагдсан иргэдийн 83.2 хувь нь төрийн байгууллагад ажилладаг бол тэдгээрийн 85.4 хувь байгууллагын шугамаар сургалтад хамрагдсан байна. Харин хувийн хэвшилд ажил эрхэлдэг иргэдийн 61.9, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 78.6 хувь нь хувийн шугамаар тус тус сургалтад хамрагджээ. Нийт судалгаанд хамрагдсан иргэдээр авч үзвэл 75.8 хувь нь буюу дөрвөн хүн тутмын гурав нь байгууллагын шугамаар хамрагдсан байна. Үүнээс харахад тус сургалтад хамрагдагсдын дийлэнх хувь нь төрийн байгууллагын шугамаар хамрагдаж байна.

График 10. Сургалтад хамрагдсан шалтгаан



Судалгаанд оролцогчдоос сургалтад хамрагдсан шалтгааныг тодруулахад тал хувь нь ажлын ур чадвараа сайжруулах үүднээс тус сургалтад хамрагдсан гэж хариулжээ. Түүний дараагаар 17.6 хувь нь ажлын газраас хамрагд гэсэн тул, 15.2 хувь нь төрийн албанд ажилд орох зорилгоор тус сургалтад хамрагдсан байна.


Төрийн албанд ажилд орох зорилгоор сургалтад хамрагдсан иргэдийн 59 хувь нь одоо төрийн байгууллагад ажилладаг гэж хариулжээ. Мөн 20.5 хувь хувийн байгууллагад, 7.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг гэж хариулсан байна. Үүнээс харахад төрийн албанд ажилд орох зорилгоор тус сургалтад хамрагдсан иргэдийн 59 хувь нь зорилгоо биелүүлж чаджээ.

Хүснэгт 1. Ажил эхлэлтийн нөхцөл байдал болон сургалтад суусан зорилго

	Төрийн байгууллага	Хувийн байгууллага	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Хөдөлмөр эрхлэхгүй байгаа	Нийт
Төрийн албанд ажилд орох зорилгоор	10.8%	38.1%	21.4%	71.4%	15.2%
Ажлын ур чадвараа сайжруулах	54.5%	42.9%	14.3%	28.6%	50.4%
Албан тушаал ахих	8.0%	0.0%	0.0%	0.0%	6.6%

Ажлын газраас хамрагд гэсэн	19.2%	14.3%	7.1%	0.0%	17.6%
Өөрийн сонирхлоороо суусан	6.6%	4.8%	57.1%	0.0%	9.4%


График 11. Бусад адил төрлийн сургалт явуулдаг байгууллагын талаар мэддэг эсэх



Судалгаанд хамрагдсан дөрвөн хүн тутмын нэг нь бусад адил төрлийн сургалтын талаар мэднэ гэж хариулжээ. Өөр сургалтын талаар мэддэг гэж хариулсан тус иргэдээс ямар шалтгаанаар АЕГ-ыг сонгосон


талаар нээлттэй асуултаар асуухад дараах үр дүн гарлаа.

График 12. Ямар шалтгаанаар АЕГ-аас зохион байгуулдаг сургалтыг сонгосон.



Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтыг сонгосон шалтгааныг нь авч үзвэл ажлын шугамаар буюу төрийн албан хаагч учир уг сургалтыг сонгосон гэж хамгийн өндөр буюу 40.9 хувь нь хариулсан байна. Харин 27.3 хувь нь чанартай сайн сургалт учир сонгосон гэж хариулжээ.

График 13. Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын талаарх мэдээлэл хүлээн авдаг суваг




АЕГ-ын Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын талаарх мэдээллийг судалгаанд оролцогчдын 66 хувь байгууллага, ажлын шугамаар хүлээж авдаг гэж үзжээ. Энэхүү судалгаанд оролцогчдын 83 хувь нь төрийн албан хаагч билээ. Үүнээс харахад төрийн албаны сүлжээ нь энэхүү сургалтын талаар мэдээлэл тарах гол суваг болж байна. Харин бусад төрлийн суваг нь төдийлөн сайн мэдээлэл түгээж хараахан чадахгүй байна.

БҮЛЭГ II. Сургалтын хөтөлбөр болон багшийн үнэлгээ

Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэхдээ хичээлийн хөтөлбөр болон багш нарыг хэрхэн үнэлж буйгаар сэтгэл ханамжтай байдлыг тодорхойллоо. Нэг талаас хөтөлбөр сайн байх, нөгөө талаас багш хөтөлбөрийг сурагчдад ойлгомжтой зааж байгаагаас сурагчдын сэтгэл ханамж шалтгаална гэж үзлээ.

График 14. Сургалтын талаар бусад хүмүүст санал болгох эсэх



Сургалтад хамрагдсан иргэдээс бусад хүнд тус сургалтыг санал болгох эсэхийг тодруулахад дийлэнх хувь нь буюу 85.6 хувь санал болгоно гэж хариулж байлаа.

График 15. Сураглтын үнэ тохиромжтой байдал

Сургалтын үнийн талаар ямар санал бодолтой байгаа судалгаанд оролцогчдоос тодруулахад суралцагчдын 85.2 хувь нь сургалтын үнэ тохиромжтой байсан гэж үзэж байлаа






График 16. Сургалтаар олж авсан мэдлэг, чадвар ажлын байранд хэр зэрэг хэрэг болдог байдал



Сургалтаар эзэмшсэн мэдлэг ур чадвар нь тухайн суралцагчийн ажлын талбарт хэр зэрэг ашиглагддаг нь тухайн хичээлийн чанартай байдлыг илтгэх гол шалгуур юм. Нийт

судалгаанд хамрагдсан суралцагчдын ердөө 2.7 хувь нь тус сургалтаар олж авсан мэдлэг огт хэрэглэгддэггүй гэж хариулсан бол дийлэнх хувь нь тодорхой хэмжээнд ажлын байранд хэрэглэгдэж байгаа гэж хариулжээ.

График 17. Сургалтаар олж авсан мэдлэг, чадвар хэрэглэгддэг байдал ажлын байраар



Сургалтаар олж авсан мэдлэг ур чадвар нь ажлын байранд нь хэрэг зэрэг хэрэгцээтэй байдаг талаар тодруулахад судалгаанд оролцогчдоос төрийн албан хаагчид хамгийн их хэрэглэдэг гэж хариулсан байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон хувийн хэвшилд хөдөлмөр эрхэлдэг суралцагчдын хувьд сургалтаар олж авсан мэдлэгээ хэрэглэх нь бага байлаа.

Судалгаанд оролцсон суралцагчдын дунд сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хийснийг дараах байдлаар хүснэгтэд харууллаа. Бид үзүүлэлт тус бүрийг 1-5 оноогоор үнэлүүлсэн бөгөөд нийт тоон үнэлгээний дундаж утгыг гаргаж хувиар тооцоолон үнэллээ.

Хүснэгт 2. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ

Сургалтын хөтөлбөр	Үнэлгээ	Хувь
Сургалтын агуулга таны хэрэгцээг хангаж чадсан эсэх	4.27	85.47
Сургалтын агуулга оновчтой байдал	4.25	85.08
Хичээлийн хөтөлбөрийн оновчтой байдал	4.18	83.59
Хичээлийн агуулга ойлгомжтой цэгцтэй байдал	4.16	83.12
Сургалтын үргэлжлэх хугацаа тохиромжтой эсэх	4.03	80.63
Практик хичээлийн хүртээмжтэй байдал	3.58	71.64
Ерөнхий үнэлгээ	4.22	84.32

Сургалтын агуулга нь тухайн суралцагчийн хэрэгцээг хангаж чадсан эсэх асуултад хамгийн өндөр буюу 85.4 хувийн үнэлгээ өгчээ. Харин тус бүлэг асуултаас практик хичээлийн хүртээмжтэй байдлыг хамгийн тааруу байдлаар буюу 71.64 хувиар үнэлсэн байна. Сургалтын хөтөлбөрийн талаар хэрэглэгчийн үнэлгээ унахад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд

- Хичээлийн хөтөлбөрт практик буюу дадлагын хичээлийн цаг хангалтгүй
- Сургалтын үргэлжлэх хугацааны тэнцвэртэй байдал нь төдийлөн тохиромжтой бус байна.
- Хичээлийн агуулга, хөтөлбөрийг шинэчлэх шаардлагатай

Үүнээс харахад сургалтын хөтөлбөрийн хувьд практик хичээлийн агуулга хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай болохыг илтгэж байна.

Хүснэгт 3. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, сургалтын хэлбэрээр

	Сургалтын хэлбэр			
	Онлайн		Танхим	
	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь
Сургалтын агуулга таны хэрэгцээг хангаж чадсан эсэх	4.39	87.71	4.23	84.62
Хичээлийн агуулга ойлгомжтой цэгцтэй байдал	4.27	85.43	4.11	82.26
Сургалтын агуулга оновчтой байдал	4.21	84.29	4.27	85.38
Хичээлийн хөтөлбөрийн оновчтой байдал	4.21	84.29	4.17	83.33
Сургалтын үргэлжлэх хугацаа тохиромжтой эсэх	3.97	79.43	4.05	81.08
Практик хичээлийн хүртээмжтэй байдал	3.44	68.86	3.63	72.69

Хүснэгт 4. Хөтөлбөрийн үнэлгээ, насны бүлгээр


	Насны бүлэг							
	24 хүртэлх		25-34		35-44		45-54	
	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь
Сургалтын агуулга оновчтой байдал	4.14	82.75	4.21	84.27	4.36	87.14	4.34	86.88
Практик хичээлийн хүртээмжтэй байдал	3.43	68.63	3.59	71.84	3.64	72.86	3.66	73.13

Хичээлийн хөтөлбөрийн оновчтой байдал	4.00	80.00	4.10	81.94	4.36	87.14	4.34	86.88
Сургалтын үргэлжлэх хугацаа тохиромжтой эсэх	3.96	79.22	4.01	80.19	4.06	81.14	4.16	83.13
Сургалтын агуулга таны хэрэгцээг хангаж чадсан эсэх	4.20	83.92	4.21	84.27	4.36	87.14	4.41	88.13
Хичээлийн агуулга ойлгомжтой цэгцтэй байдал	4.12	82.35	4.08	81.55	4.21	84.29	4.34	86.88
Нийт үнэлгээ	3.97	79.48	4.12	82.45	4.16	83.29	4.21	84.17

Хүснэгт 5. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, оршин сууж буй газраар

	Оршин суугаа газар			
	Улаанбаатар		Орон нутаг	
	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Үнэлгээ
Сургалтын агуулга оновчтой байдал	4.21	84.11	4.32	86.48
Практик хичээлийн хүртээмжтэй байдал	3.42	68.48	3.81	76.19
Хичээлийн хөтөлбөрийн оновчтой байдал	4.09	81.72	4.31	86.29
Сургалтын үргэлжлэх хугацаа тохиромжтой эсэх	3.94	78.81	4.16	83.24
Сургалтын агуулга таны хэрэгцээг хангаж чадсан эсэх	4.19	83.71	4.40	88.00
Хичээлийн агуулга ойлгомжтой цэгцтэй байдал	4.11	82.25	4.22	84.38
Нийт үнэлгээ	3.99	79.85	4.20	84.10

График 18. Сургалтын чанарыг сайжруулах тал дээр гаргасан санал (нээлттэй асуулт)



Судалгаанд оролцсон иргэдээс тус сургалтын чанарыг сайжруулахад тал дээр дээрх саналыг гаргасан байна. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ болон суралцагчдаас ирүүлсэн нээлттэй саналаар ч тэр практик, дадлага хичээлийн хүртээмж, үргэлжлэх хугацааг сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт 6. Сургалт орсон багшийн үнэлгээ

Багшийн үнэлгээ	Үнэлгээ	Хувь
Багшийн ёс зүй	4.55	91.02
Хичээлийн үеэр багшаас чөлөөтэй асуулт асуух боломжтой эсэх	4.51	90.23
Багшийн харилцааны ур чадвар	4.46	89.30
Хичээлийн агуулгаа бүрэн эзэмшсэн байдал	4.41	88.20
Багшийн цаг ашиглалт	4.35	86.95
Багшлах ур чадвар	4.32	86.33
Оролцооны арга хэрэглэдэг эсэх	3.93	78.67
Хичээлээс гадуур зөвлөгөө өгдөг байдал	3.79	75.78
Ерөнхий үнэлгээ	4.29	85.81

Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт орсон багшийн үзүүлэлтийг дээрх байдлаар үнэллээ. Судалгаанд оролцогчдын хувьд багшийн ёс зүй болон хичээлийн үеэр багшаас чөлөөтэй асуулт асуух боломжтой эсэх гэсэн асуултад хамгийн өндөр оноо буюу 90 хувиас дээш үнэлжээ. Харин багш хичээл орохдоо оролцооны арга хэрэглэдэг байдал 78.67 хувь, хичээлээс гадуур зөвлөгөө өгдөг байдалд 75.78 хувь буюу хамгийн бага оноо өгсөн байна. Сургалт орсон багшийн үнэлгээнд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

- Багш нар хичээлийн бус цагаар зөвлөгөө өгөх байдал төдийлөн хангалттай бус бөгөөд сурагчдад тус хэрэгцээ шаардлага тулгардаг.
- Хичээл заах арга барилдаа оролцооны арга хэрэгсэл ашиглах нь хангалттай бус байна.

Үүнээс харахад багш нар сургалтаас гадуур зөвлөгөө өгдөг байдал, хичээлийн үеэр оролцооны арга хэрэгсэл ашиглах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна. Энэ нь сургалтын чанарт эерэг үр нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Хүснэгт 7. Багшийн үнэлгээ, насны бүлгээр


	Насны бүлэг							
	24 хүртэлх		25-34		35-44		45-54	
	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь

Багшлах ур чадвар	4.20	83.9	4.22	84.5	4.46	89.1	4.50	90.0
Хичээлийн агуулгаа бүрэн эзэмшсэн байдал	4.27	85.5	4.36	87.2	4.54	90.9	4.50	90.0
Багшийн харилцааны ур чадвар	4.43	88.6	4.39	87.8	4.54	90.9	4.59	91.9
Багшийн ёс зүй	4.55	91.0	4.50	90.1	4.59	91.7	4.63	92.5
Хичээлээс гадуур зөвлөгөө өгдөг байдал	3.75	74.9	3.75	75.0	3.90	78.0	3.75	75.0
Оролцооны арга хэрэглэдэг эсэх	3.98	79.6	3.94	78.8	3.97	79.4	3.75	75.0
Хичээлийн үеэр багшаас чөлөөтэй асуулт асуух боломжтой эсэх	4.69	93.7	4.43	88.5	4.47	89.4	4.59	91.9
Багшийн цаг ашиглалт	4.29	85.9	4.26	85.2	4.41	88.3	4.56	91.3
Ерөнхий үнэлгээ	4.27	85.4	4.23	84.6	4.36	87.2	4.36	87.2

Хүснэгт 8. Багшийн үнэлгээ, оршин суугаа газраар

	Оршин суугаа газар			
	Улаанбаатар		Орон нутаг	
	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь
Багшийн ёс зүй	4.51	90.2	4.61	92.2
Хичээлийн үеэр багшаас чөлөөтэй асуулт асуух боломжтой эсэх	4.47	89.4	4.57	91.4
Багшийн харилцааны ур чадвар	4.39	87.8	4.57	91.4
Хичээлийн агуулгаа бүрэн эзэмшсэн байдал	4.37	87.4	4.47	89.3
Багшийн цаг ашиглалт	4.30	86.09	4.41	88.2
Багшлах ур чадвар	4.21	84.2	4.47	89.3
Оролцооны арга хэрэглэдэг эсэх	3.89	77.7	4.00	80.0
Хичээлээс гадуур зөвлөгөө өгдөг байдал	3.79	75.8	3.79	75.8
Ерөнхий үнэлгээ	4.24	84.8	4.36	87.2

График 19. Сургалтаар эзэмисэн мэдлэг, чадвартаа сэтгэл ханамжтай байдал 0-10 оноогоор



Сургалтаар эзэмшсэн мэдлэг, ур чадвартаа судалгаанд оролцогчид хэр зэрэг сэтгэл ханамжтай байгааг дээрх графикт харууллаа. Судалгаанд оролцогчдын дунд хамгийн олон нь буюу 40.6 хувь нь тус асуултад арваас найман оноо (8-10) өгсөн байна. Харин түүний дараагаар 22.3 хувь нь хамгийн өндөр буюу арван оноог өгсөн байна. Оролцогчдын сэтгэл ханамжтай байдлыг дараах байдлаар математик дундаж утгаар гаргалаа.

Хүснэгт 9. Сэтгэл ханамжийн үнэлгээ (0-10 оноогоор), сургалтын төрөл, хэрбэрээр

		Үнэлгээ	Хувь
Сургалтын хэлбэр	Онлайн	7.89	78.86
	Танхим	7.85	78.55
Сургалтын төрөл	Анхан шатны сургалт	7.79	77.87
	Мэргэшүүлэх сургалт	7.97	79.74
	Анхан шат болон мэргэшүүлэх	8.14	81.43
	Ерөнхий үнэлгээ	7.86	78.63

Сургалтад оролцогчид сургалтаар эзэмшсэн мэдлэг, ур чадвартаа хэр зэрэг сэтгэл ханамжтай байгаагаа 0-10 оноогоор үнэлэхэд нийт суралцагчдын дунджаар 7.86 оноо буюу 78.63 хувь байна.

БҮЛЭГ III. Сургалтын орчин нөхцөлийн үнэлгээ

Хүснэгт 10. Сургалтын орчин нөхцөлийн үнэлгээ.

Сургалтын орчны үнэлгээ	Үнэлгээ	Хувь
Ширээ сандалын хүрэлцээ	4.50	90.00
Анги танхимын хүрэлцээ	4.25	85.05
Машины зогсоол хүрэлцээ	4.05	81.08
Анги танхимын агааржуулалт	3.67	73.33
Анги танхимын дулаан байдал	3.51	70.11
Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчинтой эсэх	3.20	63.98
Хичээлийн бус цагаар байрлаж хичээллэх боломжтой эсэх	3.03	60.65
Компьютер тоног төхөөрөмжийн хүрэлцээ	3.02	60.32
Сургалтын байршил тохиромжтой эсэх	2.81	56.24
Ерөнхий үнэлгээ	3.56	71.19

“Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт”-ын орчин, нөхцөлийн талаар судалгаанд оролцогчид 71.19 хувьтай үнэлгээ өгсөн байна. Сургалтын орчин нөхцөлийн үнэлгээ муу гарахад дараах хүчин зүйлс нөлөөлж байна.

- Анги танхим нь зундаа агааржуулалт, өвөлдөө халаалт муу байдаг
- Хичээлийн бус цагаар хичээл давтах боломжгүй
- Компьютер, микрипон, проектор, дэлгэц зэрэг сургалтын тоног төхөөрөмж хангалттай бус байдаг
- Сургалтын байршил нь хотын төвөөс хол, очиж хичээллэхэд унаа, түгжрэл зэрэг нь хүндрэл болдог тул

Хүснэгт 11 Орчин нөхцөлийн үнэлгээ, насны бүлгээр

	Насны бүлэг							
	24 хүртэлх		25-34		35-44		45-54	
	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь
Анги танхимын хүрэлцээ	4.48	89.5	4.18	83.7	4.20	84.1	4.16	83.2
Ширээ сандалын хүрэлцээ	4.71	94.3	4.46	89.2	4.41	88.2	4.42	88.4
Машины зогсоол хүрэлцээ	4.07	81.4	4.11	82.1	3.84	76.7	4.37	87.4
Анги танхимын агааржуулалт	3.50	70.0	3.54	70.8	3.92	78.4	3.89	77.9

Компьютер тоног төхөөрөмжийн хүрэлцээ	3.36	67.1	3.00	60.0	2.96	59.2	2.47	49.5
Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчинтой эсэх	3.21	64.3	3.21	64.2	3.20	64.1	3.11	62.1
Анги танхимын дулаан байдал	3.17	63.3	3.68	73.7	3.33	66.5	4.00	80.0
Хичээлийн бус цагаар байрлаж хичээллэх боломжтой эсэх	2.95	59.0	3.25	65.0	2.80	55.9	2.95	58.9
Сургалтын байршил тохиромжтой эсэх	2.55	51.0	2.75	55.0	2.98	59.6	3.21	64.2
Ерөнхий үнэлгээ	3.56	71.1	3.58	71.5	3.51	70.3	3.62	72.4

Хүснэгт 12. Орчин нөхцөл, оршин суугаа газраар


	Оршин суугаа газар			
	Улаанбаатар		Орон нутаг	
	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь
Анги танхимын хүрэлцээ	4.20	83.9	4.33	86.6
Ширээ сандалын хүрэлцээ	4.42	88.4	4.61	92.2
Машины зогсоол хүрэлцээ	4.07	81.3	4.04	80.8
Анги танхимын агааржуулалт	3.52	70.5	3.86	77.2
Анги танхимын дулаан байдал	3.36	67.3	3.70	73.9
Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчинтой эсэх	3.18	63.6	3.23	64.6
Хичээлийн бус цагаар байрлаж хичээллэх боломжтой эсэх	3.00	60.0	3.08	61.5
Компьютер тоног төхөөрөмжийн хүрэлцээ	2.86	57.2	3.23	64.6
Сургалтын байршил тохиромжтой эсэх	2.72	54.4	2.94	58.7
Ерөнхий үнэлгээ	3.48	69.6	3.67	73.3

График 20. Сургалтын орчин, нөхцөлтэй холбоотой санал (нээлттэй асуулт)




Сургалтад танхимаар хамрагдсан иргэдээс орчин нөхцөлтэй холбоотой нээлттэй асуултад дээрх үр дүн гарлаа. Анги танхим, тоног төхөөрөмжтэй холбоотой асуудал нь нэн түрүүнд бэрхшээл болдог гэж судалгаанд хамрагдсан иргэдийн 40.4 хувь нь үзсэн бол 19.1 хувь нь сургалтын байршил хол байгаа нь хүндрэл болдог гэж үзжээ. Сургалтын байршил хол байгаа тул хотын төвд сургалтын байртай болох гэсэн санал олон гарч байлаа.

График 21. Танхимын сургалтын орчин, нөхцөлийн сэтгэл ханамжийн үнэлгээ (0-10 оноогоор үнэлэв)




Сургалтын орчин нөхцөлд танхимаар сургалтад хамрагдсан иргэдийн сэтгэл ханамж ямар түвшинд байгааг дээрх графикт харууллаа. Графикт иргэд танхимын сургалтын орчин, нөхцөлд 0-10 онооны хооронд хэрхэн үнэлгээ өгснийг тархааж харууллаа. Судалгаанд оролцогчдын ерөнхий үнэлгээ 7.08 оноо байна.

График 22. Онлайн сургалтын нөхцөл байдлын үнэлгээ (0-10 оноогоор)



Онлайн хэлбэрээр сургалтад оролцсон иргэдээс сургалтын нөхцөл байдалд хэр зэрэг сэтгэл ханамжтай байгааг 0-10 оноогоор үнэлүүлсэн бөгөөд үнэлгээний давтамжийн тархалтыг графикт дүрслэн харууллаа. Судалгаанд оролцогчид онлайн сургалтын орчин нөхцөлийг 7.26 оноогоор үнэлжээ.

График 23. Онлайн сургалтын үед тохиолддог хүндрэлүүд



Онлайн хэлбэрээр сургалтад оролцсон иргэдээс гарсан хүндрэл бэрхшээлийг тодруулахад ажлын цагтай давхацдаг байсан нь хүндрэлтэй байсан гэж 36.4 хувь нь үзжээ. Түүний дараагаар онлайн сургалтын оролцогчид олон байдаг тул хүн бүр тэгш оролцох боломжгүй байсан нь нэлээд хүндрэл болдог байна. Мөн сүлжээний гацалт, тоног төхөөрөмжтэй холбоотойгоор асуудал гардаг байсан гэж 20.5 хувь нь үзсэн байна.

Хүснэгт 13. Танхимын болон онлайн сургалтын орчин нөхцөлийн үнэлгээ

	Сургалтын орчин нөхцөлийн сэтгэл ханамж		Онлайн сургалтын нөхцөл байдлын сэтгэл ханамж	
	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь
Анхан шатны сургалт	6.99	69.93	6.80	68.00
Мэргэшүүлэх сургалт	7.44	74.38	7.55	75.45
Анхан шат болон мэргэшүүлэх	7.53	75.29	7.71	77.06
Онлайн		0.00	7.26	72.61
Танхим	7.08	70.81		0.00
Нийт	7.08	70.81	7.26	72.61

Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ

Хүснэгт 14. “Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт”-д хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ

	Үнэлгээ	Хувь
Хөтөлбөрийн үнэлгээ	4.22	84.32
Багшийн үнэлгээ	4.29	85.81
Орчин нөхцөлийн үнэлгээ	3.56	71.19
Ерөнхий дүн	4.02	80.47

ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Бидэнд ирсэн сургалтад хамрагдсан хүмүүсийн мэдээлэл дунд байршил, болон нас, хүйс зэрэг хүн ам зүйн мэдээлэл байгаагүй хэдий ч бид судалгааны түүвэрлэлтийг байгаа мэдээлэлдээ тулгуурлан аль болох тэнцвэртэй мэдээлэл цуглууллаа. Цаашид Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад хамрагдсан хүмүүсийн хүн ам зүйн мэдээллийг бүртгэн авч байх нь АЕГ-ын дотоод мэдээллийн санг өргөжүүлэх, сургалтын цар хүрээг илүү нарийвчлалтайгаар харахад тустай.
2. Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад хамрагдсан иргэд сургалтын хөтөлбөрийг шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна. Судалгаанд оролцсон иргэд сургалтын хөтөлбөрийг 4.22 оноо буюу 84.32 хувиар үнэлжээ.
3. Сургалтын хөтөлбөрт практик буюу дадлага хичээл төдийлөн хангалттай биш байна. Суралцагсад цаашлаад дадлага хичээлийг үр нөлөөтэй зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна. Мэргэшүүлэх сургалтын хугацааг уртасгах шаардлагатай.
4. Архив, албан хэргийн сургалтын багш нарын үнэлгээ 4.29 оноо буюу 85.81 хувьтай байна. Тус оноонд багш нарын хичээлийн бус цагаар зөвлөгөө өгдөг байдал болон хичээлдээ оролцооны арга хэрэгсэл ашиглахгүй байгаа нь нөлөөлж байна. Мөн зарим тохиолдолд багш нарын заасан хичээл хоорондоо зөрчилдөх тохиолдол гарч байсны судалгаанд оролцогчид онцоллоо.
5. Сургалтын орчин нөхцөлийг судалгаанд оролцогчид 3.56 оноо буюу 71.19 хувиар үнэлсэн байна. Энэ нь тус судалгааны явцад хамгийн бага үзүүлэлт болж байна.
6. Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын орчин нөхцөлийн үнэлгээ унахад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:
 - Сургалтын байршил хол
 - Сургалтын танхимын орчин нөхцөл тааруу байдал (сургалтын танхим нь зундаа агааржуулалтгүй бүгчим, өвөлдөө хүйтэн, техник тоног төхөөрөмж нь шаардлага хангадаггүй)
 - Практик дадлагын бааз байхгүйзэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.
7. Сургалтын хөтөлбөр, багш, орчин нөхцөл ерөнхий дүнгээр 5-аас 4.02 буюу 80.47%-ийн үнэлгээ авсан байна.

8. Сургалтаар олж авсан мэдлэг, чадварын сэтгэл ханамж 10-аас 7.86 (78.6%) оноо байна.
9. Сургалтын орчин нөхцөлийн сэтгэл ханамж 10-аас 7.08 (70.8%) оноо байна.
10. Онлайн сургалтын сэтгэл ханамж 10-аас 7.26 (72.6%) оноо байна.

Санал зөвлөмж

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын хөтөлбөрийг сайжруулах.
2. Сургалтын практик, дадлагын хичээлийн цагийг үр уртасгах, чанартай дадлагын хөтөлбөрийг боловсруулах. Дадлагыг АЕГ-ын материаллаг баазад тулгуурлан бодит нөхцөлд хийж гүйцэтгэх.
3. Багш нар өөрийн зааж буй хичээлийн агуулгын дагуу суралцагчидтай биечлэн харилцаж заавар зөвлөгөө өгдөг байх. Хичээлдээ суралцагчидтайгаа харьцсан оролцооны аргыг хэрэглэдэг болох.
4. Хичээлийн танхимыг орчин үеийн стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах.
5. Хичээлийн орчин нөхцөлийн агааржуулалт, дулааны асуудлыг шийдвэрлэх.
6. Практик, дадлагын танхимтай болох, түүндээ суралцагчид хичээлийн бус цагаар ч өөрийн сайн дураар хичээллэх боломжтой байдлаар зохион байгуулалт хийх.
7. Хичээлийн бус үед суралцагчид бие даан хичээллэх танхим болон багшаас зөвлөгөө авах цагуудыг хичээлийн хөтөлбөрт тусгаж өгөх.